



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 1120

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн баталгаажуулах, зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 1 дүгээр, аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг 2 дугаар, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Татварын ерөнхий газрын Зохион байгуулалтын нэгжид хүргүүлэх зөвлөмжийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Нийслэлийн хэмжээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хангалтгүй дүгнэгдсэн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, албан хаагчийн ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, сар бүрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийслэлийн татварын газар (М.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хангалтгүй үнэлгээтэй дүгнэгдсэн үзүүлэлт тус бүрийн гүйцэтгэлийг сайжруулах, оны эцэст гүйцэтгэлийг төлөвлөсөн түвшинд хүргэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх, албан хаагчийн ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг сарын ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дүгнэж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын 3 дугаар хавсралтад тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцон 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Татварын ерөнхий газрын Даргын зөвлөлд танилцуулахыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газрын дэд дарга (А.Энхболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЗАЯАБАЛ

152311746

Татварын ерөнхий газрын даргын
 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн
 А/120 дугаар тушаалын 2 дугаар
 хавсралт

**Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл,
 дүүргийн татварын хэлтсийн 2023 оны хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн
 хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн**

Д/д	Татварын албадын нэр	Нийт оноо	Үнэлгээ	
Татварын ерөнхий газрын харьяа нэгж				
1	МТТ	88.69	*В*	*Сайн*
2	Том татвар төлөгчийн газар	73.05	*С*	*Сайжруулалт хэрэгтэй*
Аймаг, нийслэл, дүүргийн татварын албад				
1	Архангай	83.91	*В*	*САЙН*
2	Багануур	82.58	*В*	*САЙН*
3	Нийслэл	82.09	*В*	*САЙН*
4	Говь-Алтай	79.63	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
5	Булган	79.62	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
6	Дорнод	79.01	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
7	Өвөрхангай	78.88	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
8	Сүхбаатар	78.85	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
9	Завхан	78.80	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
10	Чингэлтэй	78.39	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
11	Дархан-Уул	78.14	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
12	Өмнөговь	77.91	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
13	Сүхбаатар дүүрэг	77.40	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
14	Хөвсгөл	77.29	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
15	Орхон	77.07	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
16	Сэлэнгэ	76.77	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
17	Хэнтий	75.58	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
18	Увс	74.69	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
19	Баян-Өлгий	74.66	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
20	Налайх	74.45	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
21	Сонгинохайрхан	74.05	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
22	Баянхонгор	73.99	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
23	Баянзүрх	73.79	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
24	Дундговь	72.46	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
25	Баянгол	72.43	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
26	Дорноговь	72.28	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
27	Ховд	71.22	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
28	Хан-Уул	71.02	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
29	Говьсүмбэр	70.65	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
30	Төв	70.51	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*
31	Багахангай	60.00	*D*	*ХАНГАЛТГҮЙ*